



МОНГОЛ УЛС  
ЁС ЗҮЙН ХОРООНЫ  
ТОГТООЛ

2024 оны 11 сарын 22 өдөр

Дугаар 15

Улаанбаатар хот

Сургалтын агуулга, сэдэв батлах тухай

Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.6.3 дахь заалт, Улсын Их Хурлын 2024 оны 27 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр”-ийн 2.1.2, 2.1.5 дахь заалт, Улсын Их Хурлын Ёс зүй, сахилга, хариуцлагын байнгын хорооны 2023 оны 04 дүгээр тогтоолоор батлагдсан “Ёс зүйн хорооны үйл ажиллагааны дүрэм”-ийн 2.1 дэх хэсгийн 2.1.3.2, 2.1.3.3 дахь заалт, 3.5 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг сахиулах, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг нэгдсэн удирдлагаар хангах, зохион байгуулах хүрээнд “Төрийн албан хаагчийн ёс зүйн сургалтын агуулга”-ыг нэгдүгээр, Ёс зүйн дэд хороодын чадавхыг бэхжүүлэх, сургагч багш бэлтгэх сургалтын агуулга, сэдвийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Батлагдсан агуулгын хүрээнд төрийн албан хаагчийн ёс зүйн сургалтын хөтөлбөр боловсруулж, сургалт зохион байгуулан, үр дүнг тухайн жилийн улирал бүр Ёс зүйн хороонд тайлагнаж ажиллахыг төрийн бүх шатны байгууллагын томилох эрх бүхий албан тушаалтан, Ёс зүйн дэд хороодод тус тус үүрэг болгосугай.

3.Ёс зүйн дэд хороодын чадавхыг бэхжүүлэх, сургагч багш бэлтгэх сургалтын агуулга, сэдвийн хүрээнд хөтөлбөр, гарын авлага боловсруулж, сургалт зохион байгуулахыг Ёс зүйн хорооны Ажлын алба (Н.Ганбаатар)-д үүрэг болгосугай.

4.Энэ тогтоолын хэрэгжилтийг мэргэшил, арга зүйн удирдлагаар хангаж, биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Ёс зүйн хорооны Ажлын алба (Н.Ганбаатар)-д даалгасугай.

ДАРГА

  
Ц.АМАРТӨГС

2400030

Ёс зүйн хорооны 2024 оны 11 сарын 15 өдрийн 15 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралт

ATA11169 8448906  
902311371

Төрийн албан хаагчийн ёс зүйн сургалтын агуулга

Д/д	Агуулгын хүрээ	Албан тушаалын төрөл: Гүйцэтгэх			Албан тушаалын төрөл: Удирдах		
		Зорилго: Ажил, үүргээ ёс зүйтэй гүйцэтгэх мэдлэг, чадвараа сайжруулах	Зорилго: Ёс зүйг дээдэлсэн соёлыг бүрдүүлэх үйл ажиллагааг удирдан зохион байгуулах, манлайлах мэдлэг, чадвараа сайжруулах	Түвшин			
		Суурь	Дунд	Ахисан	Суурь	Дунд	Ахисан
1	Агуулгын хүрээ 1 Төрийн албаны үнэт зүйл, суурь зарчим (хүний эрх, жендерийн эрх тэгш байдал г.м)	Нийт иргэд, улсын ашиг сонирхол	Төрийн албан хаагчийн эрхэмлэн дээдлэх үнэт зүйл	Төрийн албаны үнэт зүйл, зарчим	Төрийн албаны үнэт зүйл, зарчим, ёс зүйн онцлог	Төрийн албаны үнэт зүйл, уламжлал, шинэчлэл	Төрийн албаны үнэт зүйл, уламжлал шинэчлэл
2	Агуулгын хүрээ 2 Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг тодорхойлсон тогтоомжийн баримтлал	Төрийн албан хаагчийн ёс суртахууны тухай үндсэн ойлголт	Төрийн албан хаагчдад тавигдах ёс суртахууны нийтлэг шаардлага	Ёс зүйн харилцааг зохицуулах хууль тогтоомжийн үзэл баримтлал, хэрэгжилт	Ёс зүйн хэм хэмжээ, эрх зүйн зохицуулалт, хариуцлагын тогтолцоо	Ёс зүйн хэм хэмжээг сахин эрх мэдлийг хэрэгжүүлэх нь	Эрх мэдлийг ёс зүйтэй хэрэгжүүлэх нь
3	Агуулгын хүрээ 3 Ёс зүйн хэм хэмжээг мөрдөх төрийн албан хаагчийн (харилцааны хэм хэмжээ, цахим орчны ёс суртахуун г.м)	Ёс зүйн хэм хэмжээг зохицуулах хууль тогтоомжийн үзэл баримтлал	Ёс зүйн зөрчлийн шалтгаан, үр дагавар	Ёс зүйн зөрчлөөс сэргийлэх арга зам	Ёс зүйн эргэлзээтэй байдлын тухай ойлголт	Ёс зүйн эргэлзээтэй байдал, шийдвэр гаргалт	Ёс зүйг дээдлэн шийдвэр гаргах нь
4	Агуулгын хүрээ 4 Ёс зүйг дээдэлсэн орчин бүрдүүлэх арга механизм	Ажлын байранд гаргах зан төлөв	Байгууллагын соёл, дэг журам, албан харилцааны ёс зүйг сахин мөрдөх чиглэл	Харилцаа, зөрчилдөөнийг зохицуулах механизм	Ёс зүйн зөрчилд дүн шинжилгээ хийх арга зүй: шалтгаан, нөхцөл, эрсдэл тооцох	Ёс зүйн менежментийн дэд бүтэц, бүрдүүлэх арга хэрэгсэл	Ашиг сонирхлын зөрчил, авлигыг үл тэвчих орчин бүрдүүлэх удирдамж, чиглэл

5	Агуулгын хүрээ Ёс зүйг дээдэлсэн байгууллагын тухай ойлголт, төлөвшүүлэх ажиллагаа дахь төрийн албан хаагчийн оролцоо	Ёс зүйг дээдэлсэн байгууллагын соёлын тухай ойлголт, ач холбогдол	Төрийн албан хаагчийн харилцаа, хандлага, баримтлах зарчим	Ёс зүйг дээдэлсэн байгууллагын соёлыг төлөвшүүлэхэд төрийн албан хаагчийн оролцоо	Ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны удирдлага, зохион байгуулалт	Удирдах албан тушаалтны ёс зүйтэй манлайлал	Ёс зүй, шударга байдлаар үлгэрлэн манлайлах нь
<b>Сургалтын үр дүн, шалгуур үзүүлэлт</b>							
Гүйцэтгэх				Удирдах			
Сургалтын үр дүн, шалгуур		Түвшин					
Д/д	Сургалтын үр дүн, шалгуур	Суурь	Дунд	Ахисан	Суурь	Дунд	Ахисан
1	Сургалтын үр дүн	Ёс суртахууны үнэ цэнэ, ач холбогдлын талаарх мэдлэг эзэмших	Ёс зүйн үзэл баримтлалыг хэрэглэх мэдлэг, чадварын түвшин сайжирсан байна.	Ёс зүйтэй ажиллах орчин, нөхцөлийг бүрдүүлэхэд оруулах хувь нэмрийн талаарх мэдлэгийн түвшин нэмэгдсэн байна.	Ёс зүйн төлөв байдалд дүн шинжилгээ хийх, зөрчлөөс урьдчилан сэргийлэх мэдлэгийн түвшин нэмэгдсэн байна.	Ёс зүйг дээдэлсэн соёлыг төлөвшүүлэх үйл ажиллагааг салбар, байгууллагын хүрээнд удирдан зохион байгуулах мэдлэгийн түвшин нэмэгдсэн байна.	Салбар, байгууллагын түвшинд ёс зүйгээр үлгэрлэн манлайлах талаар мэдлэгийн түвшин нэмэгдсэн байна.
2	Гарцын шалгуур үзүүлэлт (output)	Хичээлийн агуулгаар эзэмшсэн мэдлэг шалгах сорил, шалгалтын дүн (Хэмжих нэгж-хувь)	Хичээлийн агуулгаар эзэмшсэн мэдлэг шалгах сорил, шалгалтын дүн (Хэмжих нэгж-хувь)	Хичээлийн агуулгаар эзэмшсэн мэдлэг шалгах сорил, шалгалтын дүн (Хэмжих нэгж-хувь)	Төрийн байгууллагын ёс зүйн зөрчилд дүн шинжилгээ хийж, шийдэл боловсруулсан төлөвлөгөөний даалгаврын дүн	Ёс зүйн менежментийн дэд бүтцийг бүрдүүлэх чиглэлээр боловсруулсан төлөвлөгөөний үнэлгээ /үсгэн дүн, хувиар/	Ёс зүйн хоёрдмол байдлын холбогдох кэйс шийдсэн байдлын үнэлгээ /үсгэн дүн, хувиар/
3	Үр дагаврын шалгуур үзүүлэлт (outcome)	Дотоод шударга байдлын үнэлгээ	Дотоод шударга байдлын үнэлгээ	Гадаад шударга байдлын үнэлгээ	Гадаад шударга байдлын үнэлгээ	Бодлогод оролцогчдын үнэлгээ	Бодлогод оролцогчдын үнэлгээ
4	Үр нөлөөний шалгуур үзүүлэлт (impact)	"Транспэрэнси интернэшнл" байгууллагаас жил бүр тооцон гаргадаг авлигын төсөөллийн судалгаагаар Монгол улсын жагсаалтад эзэлсэн эрэмбэ, индекс					

Ёс зүйн хорооны 2024 оны 11 сарын 22 өдрийн 14 дугаар тогтоолын хоёрдугаар хавсралт

ATA11169 8448906  
902311371

**Ёс зүйн дэд хороодын чадавхыг бэхжүүлэх, сургагч багш бэлтгэх сургалтын агуулга, сэдэв**

Д/д	Ёс зүйн дэд хороодын чадавхыг бэхжүүлэх сургалтын зорилго: Ёс зүйн нийтлэг хэм хэмжээг сахиулах, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг байгууллагын түвшинд удирдан зохион байгуулах онол арга зүйн мэдлэг, чадвараа сайжруулах	Нийтлэг сэдэв	Агуулга	Нийтлэг сэдэв
1	Агуулгын хүрээ 1 Ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагааны удирдлага зохион байгуулалт, онцлог	<ul style="list-style-type: none"> <li>Байгууллагын түвшинд албан хаагчдыг ёс зүйн хэм хэмжээг мөрдүүлэн ажиллуулах арга зүй;</li> <li>Зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагааны тухай ойлголт, зарчим, онцлог, тавигдах шаардлага, анхаарах үндсэн асуудал.</li> </ul>	Агуулгын хүрээ 1 Насанд хүрэгчдийн онцлог, сургалтын андрогог	<ul style="list-style-type: none"> <li>Сургалтын онол үзэл баримтлал, насанд хүрэгчдийн сэтгэл зүйн онцлог, андрогог буюу насанд хүрэгчидтэй ажиллах арга барил, зарчим, хичээлийг практикт уялдуулах, суралцагчдын бие даасан байдал, харилцан суралцах үйл явцыг хөхиүүлэн дэмжих</li> </ul>
2	Агуулгын хүрээ 2 Ёс зүйн сургалтын агуулга боловсруулах, сургалт зохион байгуулах онол, арга зүй	<ul style="list-style-type: none"> <li>Насанд хүрэгчдийн сургалтын онцлог, ёс зүйн сургалтын хэрэгцээг тодорхойлох нь;</li> <li>Ёс зүйн сургалтын сэдэв, хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулалт;</li> <li>Кэйст суурилсан сургалтын арга зүй;</li> <li>Ёс зүйг төлөвшүүлэх чиглэлээр тасралтгүй суралцах зарчим.</li> </ul>	Агуулгын хүрээ 2 Ёс зүйн сургалтыг зохион байгуулах арга зүй	<ul style="list-style-type: none"> <li>Сургалт зохион байгуулах арга зүй, сургалтын хэрэглэгдэхүүн боловсруулах, хичээлийн үнэлгээ, заах арга зүй, интерактив арга зүй (лекц, багийн ажил, кэйс, тоглоом, дүрд тоглох)</li> </ul>
3	Агуулгын хүрээ 3 Ёс зүйн асуудлаар зөвлөн туслах үйл ажиллагаа	<ul style="list-style-type: none"> <li>Зөвлөн туслах, дэмжлэг үзүүлэх арга зүйн ойлголт;</li> <li>Ёс зүйн зөрчил гаргаж болзошгүй эрсдэлт бүлгийг тодорхойлох нь;</li> <li>Мэдээллийн найдвартай байдлыг хангах;</li> <li>Үйлчлүүлэгч төвтэй хандлага;</li> </ul>	Агуулгын хүрээ 3 Ёс зүйн хичээлийн агуулга, суралцагчдад эзэмшүүлэх мэдлэг чадвар	<ul style="list-style-type: none"> <li>Ёс зүйн хичээлийн үндсэн ухагдахуун, ёс зүйн үзэл баримтлал, заах хичээлийн агуулга, мөн чанар, суралцагчдад эзэмшүүлэх шаардлагатай мэдлэг чадвар</li> </ul>

		<ul style="list-style-type: none"> <li>Зөвлөн туслах үйл ажиллагаанд тулгамддаг сорилт, шийдэл.</li> </ul>		
4	Агуулгын хүрээ 4 Ёс зүйн зөрчлийг бусад зөрчлөөс ялган тодорхойлох арга зүй	<ul style="list-style-type: none"> <li>Зөрчлийн төрөл /сахилгын, захиргааны/ хэлбэрүүд;</li> <li>Ёс зүйн зөрчил, зөрчлийг ялган танихад үүсэх сорилт, шийдэл.</li> </ul>	Агуулгын хүрээ 4 Агуулгыг эзэмших, харилцан суралцах, санал солилцох талбарыг тодорхойлох	<ul style="list-style-type: none"> <li>Агуулгыг эзэмших, хичээл заах, харилцан суралцах, санал дэвшүүлэх, цаашид сайжруулах талбарыг тодорхойлох дадлага ажил</li> </ul>
5	Агуулгын хүрээ 5 Ёс зүйн зөрчлийг шалгасан дүгнэлт: эрх зүйн үндэслэл	<ul style="list-style-type: none"> <li>Гомдлыг хянан шийдвэрлэх үйл ажиллагааны зарчим;</li> <li>Тодруулга мэдээлэл авах, мэдээ баримтад дүн шинжилгээ хийх, ёс зүйн зөрчил гаргасан эсэхийг тогтоон, дүгнэлт гаргах.</li> </ul>	Агуулгын хүрээ 5 Ёс зүйн сургалт зохион байгуулахад анхаарах асуудал, сорилт, шийдэл	<ul style="list-style-type: none"> <li>Сургалт зохион байгуулахад үүсэх сорилт: Байгууллагын онцлог, соёлтой холбоотой үүсэх бэрхшээл, шийдэл;</li> <li>Сорилтыг шийдвэрлэх арга зам, цаашдын сургалтын үйл ажиллагааны чиглэл, цагийн менежмент.</li> </ul>
6	Агуулгын хүрээ 6 Ёс зүйн зөрчлийг хянан шийдвэрлэж хариуцлага тооцсон захиргааны акт: эрх зүйн үндэслэл	<ul style="list-style-type: none"> <li>Ёс зүйн талаарх холбогдох хууль, дүрэм, журмыг боловсруулахад анхаарах асуудал</li> </ul>	-	-
<b>Үр дүн</b>				
1	<ul style="list-style-type: none"> <li>Ёс зүйн хууль тогтоомжийг таниулах, зөрчлөөс урьдчилан сэргийлэх сургалт, нөлөөллийн ажлыг үр дүнтэй зохион байгуулах үр чадвар эзэмшсэн байна.</li> <li>Ёс зүйн асуудлаар зөвлөгөө өгөх, ёс зүйг дээдэлсэн орчныг бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлсэн байна.</li> <li>Дэд хорооны үйл ажиллагааг шинэ арга барилаар зохион байгуулах сэтгэлгээний зэрэг өөрчлөлтийг бий болгоно.</li> </ul>			<ul style="list-style-type: none"> <li>Ёс зүйн сургалтыг бие даан зохион байгуулах арга зүйг эзэмшсэн байна.</li> <li>Сургалтын идэвхтэй аргуудыг ашиглан ёс зүйн сургалтыг бие даан зохион байгуулсан байна.</li> <li>Багшийн үнэлгээ, хөтөлбөр боловсруулалт, төлөвлөлт, зохион байгуулалт, эргэх холбоог уялдуулан сургалтын үр дүнг нэмэгдүүлсэн байна.</li> </ul>